



УУЛ УУРХАЙН ЯАМ

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

ХШҮДАГ-ын дарга Д.ЖАВХЛАНБОЛД

ТЗУГ-ын дарга Д.БАТБОЛД

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Н.БААТАР

Улаанбаатар хот 2014 он

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллага УУЛ УУРХАЙН ЯАМ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд,

Монгол Улсын төрийн захиргааны байгууллага АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР , ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР нь дээр дурьдсан хууль тогтоомж, акт болон Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ-д “Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлд заасан ёсоор Засгийн газар нь Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. Засгийн газар Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”,

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ-д “Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн. Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж тус тус хуульчлан заасан.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ-ийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-д Уул уурхайн сайд нь геологи, эрдэс баялгийн бодлого; газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого; олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал; ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ гэж заасан.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ЯАМДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙГ БАТЛАХ ТУХАЙ
Засгийн газрын 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр
тогтоолоор Уул уурхайн зохион байгуулалтын бүтцийг дор
дурдсанаар баталсан. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын газар /хуулийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй/,
 2. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /геологийн бодлогын хэлтэс, уул уурхайн бодлогын хэлтэс, түлшний бодлогын хэлтэс, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэстэй/,
 3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар,
 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
-

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР-т тус яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлсон.

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО нь Монгол Улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг баяжуулж, уул уурхайн салбарыг хөгжүүлэн, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл болон нийгэм, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дэмжиж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уул уурхайн яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх;
 2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө өгөх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 3. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
 4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрдслийн удирдлагаар хангах.
-

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ-д “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн” гэж чиг үүргийг тодорхойлсон.

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ОРОН ТОО БАТЛАХ ТУХАЙ Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ний өдрийн 43 дугаар тогтоолоор Ашигт малтмалын газар /АМГ/ болон Газрын тосны газар /ГТГ/-ын орон тоог баталсан.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ-ийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй”, 4 дэх хэсэгт “хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө”, 2 дахь заалтад “Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана”, **ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**-ийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын сайд батална” гэж тус тус заасны дагуу **Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайд нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан.**

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ БҮТЭЦ



ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Засгийн газрын 2012.09.29-ний өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн үйл ажиллагааны стратегийн 2.4.4-т заасан “Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах” зорилтыг Уул уурхайн яамны **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР** хэрэгжүүлж байна

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

ХШҮДАГ нь үйл ажиллагаандаа дээр дурьдсан хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангаж, уялдаа холбоог ханган ажиллахад чиглэгдэнэ.

- ❑ Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
 - ❑ Төрийн аудитын тухай хууль,
 - ❑ МУИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013.05.07-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”,
 - ❑ Засгийн газрын 2013 оны 322 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”,
 - ❑ Засгийн газрын 2009.05.14-ний өдрийн 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”,
 - ❑ Засгийн газрын 2011.11.09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”,
 - ❑ Засгийн газрын 2012.11.17-ний өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” зэрэг
-

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Уул уурхайн сайдын эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомж , урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон дараах баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах замаар яамны удирдлагуудыг эрсдэлийн удирдлагаар ханган ажиллана. Үүнд:

- ❑ УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”,
 - ❑ УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
 - ❑ УИХ-ын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл

 - ❑ Үндэсний хөтөлбөр,
 - ❑ Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэж буй төсөл,
 - ❑ Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр,
 - ❑ Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, иргэд байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдол зэрэг
-

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ-ийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь *“газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх,”*, 52.1-т “Геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд тус тус хяналт тавина” гэж заасан. Мөн хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт *“Газрын хэвлийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол геологи, уул уурхайн болон байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:”* гэж заасан.

Геологи, хайгуул, ашиглалт, олборлолт, уурхайн хаалт, нөхөн сэргээлтэд геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч хяналт тавьж хэрэгжүүлэх, хариуцлага тооцохоор заасан.

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2002 оноос өнөөг хүртэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар улсын хэмжээнд хяналтыг төвлөрүүлэн хэрэгжүүлж ирсэн бөгөөд дээрхи хугацаанд уул уурхайн нөхөн сэргээлт, уурхайн хаалт, технологийн хяналт, ашигт малтмалын нөөцийн хяналт алдагдаж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм мөрдөгдөхгүйгээс осол аварийн тоо хэмжээ ихсэж, байгаль орчинд хор хохирол ихээр учруулах болсон тул Улсын Их хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар бүлэгт **“салбарын мэргэшсэн хяналтын байгууллага бий болгох”**, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 305-д “Мэргэжлийн хяналтын байгууллагыг өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан хяналт шалгалтын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна”, “Салбарын хяналтын байцаагчдыг хариуцсан асуудлын чиглэлээр давтан сургаж, мэргэшүүлнэ” гэсэн зорилтыг шинэчлэлийн Засгийн газраас дэвшүүлэн ажиллаж байна.

**Анхаарал тавьсанд
баярлалаа**
